



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 08 өдөр

Дугаар А/60

Мөрөн сум

Төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн ээлжит XVI хуралдааны 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Орон нутгийн хөгжлийн сан дахь “Зураг төсвийн сангийн шилжих хөрөнгө оруулалт”-аар санхүүжүүлэх барилга, байгууламжийн зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээнд зарцуулах хөрөнгийг хавсралтаар баталсугай.

2. Хавсралтад дурдсан 26 төсөл арга хэмжээний зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний санхүүжилтэд шаардлагатай 402,820,800 (Дөрвөн зуун хоёр сая найман зуун хорин мянга найман зуу) төгрөгийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу шилжих зураг төсвийн сангаас гаргаж зарцуулахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Б.Оюунтуяа), Санхүү, төрийн сангийн хэлтэс (Г.Базар) нарт тус тус даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Мөнгөн-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Захирамж-2023

6712010287

Аймгийн Засаг даргын 2023 оны 02 дугаар
сарын 08-ын өдрийн 460 дугаар
захирамжийн хавсралт

АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН ДАХЬ “ЗУРАГ ТӨСВИЙН САН ШИЛЖИХ”-
ЭЭС САНХҮҮЖҮҮЛЭХ ШИНЭЭР БАРИХ, ЗАСВАРЛАХ, ШИНЭЧЛЭХ, БАРИЛГА
БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ТӨЛБӨРИЙН ТӨСӨВТ ӨРТГИЙН ДЭЭД ХЯЗГААР

| № | Арга хэмжээний нэр | Төсөвт өртөг | Тайлбар |
|---|---|--------------|---|
| 1 | “Иргэдэд төрийн үйлчилгээг нэг цэгээс түргэн шуурхай хүргэх, төрийн үйлчилгээний нэгдсэн төв”-ийн барилгын ажлын зураг төсөл боловсруулах | 18,000,000 | Холбогдох хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт заасан шаардлагыг хангасан байна |
| 2 | Нийтийн номын сангийн Хүүхдийн уншлагын танхим, вестибюль, гадна фасатны засварын ажлын зураг төсөл боловсруулах | 9,850,000 | Холбогдох хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт заасан шаардлагыг хангасан байна |
| 3 | Эрдэнэбулган сумын Засаг даргын Тамгын газрын барилгын их засварын ажлын зураг төсөл боловсруулах | 11,800,000 | Холбогдох хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт заасан шаардлагыг хангасан байна |
| 4 | Галт сумын ЗДТГ-ын барилгын ажлын зураг төсөл боловсруулах | 25,000,000 | Холбогдох хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт заасан шаардлагыг хангасан байна |
| 5 | “Зүүн-Мөрөн” хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг шинэчилж төлөвлөх ажлын зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээ | 89,908,000 | Холбогдох хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт заасан шаардлагыг хангасан байна |
| 6 | Ахмад настны асрамж үйлчилгээний төвийн барилгын ажлын зураг төсөл боловсруулах | 39,051,000 | Холбогдох хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт заасан шаардлагыг хангасан байна |
| 7 | Сумын төвийн хогийн цэгийг дарж булшлах ажлын зураг төсөл боловсруулах /Тариалан сум/ | 35,000,000 | Холбогдох хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт заасан шаардлагыг хангасан байна |
| 8 | Тосонцэнгэл сумын Эрүүл мэндийн төвийн барилгын гадна бохирын | 4,500,000 | Холбогдох хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт |

| | | | |
|----|--|------------|---|
| | цооногийн ажлын зураг төсөл боловсруулах | | бичигт заасан шаардлагыг хангасан байна |
| 9 | Бүрэнтогтох сумын Бүрэнхаан багийн бага сургуулийн спорт заал, хүний эмчийн байрыг халаалтад холбох ажлын зураг төсөл боловсруулах | 4,500,000 | Холбогдох хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт заасан шаардлагыг хангасан байна |
| 10 | "Урандөш" зуслангийн амрагчдийн дүнзэн байшингийн ажлын зураг төсөл боловсруулах | 2,500,000 | Холбогдох хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт заасан шаардлагыг хангасан байна |
| 11 | Зорилтод сумдад төмс, хүнсний ногоо тариалах талбайд усжуулалтын систем байгуулах ажлын зураг төсөл боловсруулах | 2,000,000 | Холбогдох хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт заасан шаардлагыг хангасан байна |
| 12 | "Шинэ Мөрөн" орон сууцны хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний зүүн урд хэсгийн төлөвлөлтийг шинэчилж төлөвлөх ажлын зураг төсөл боловсруулах | 19,250,000 | Холбогдох хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт заасан шаардлагыг хангасан байна |
| 13 | Алаг-Эрдэнэ сумын Хатгал тосгоны 15 ортой эрүүл мэндийн төвийн барилгын ажлын зураг төсөл боловсруулах | 32,000,000 | Холбогдох хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт заасан шаардлагыг хангасан байна |
| 14 | Гэр бүлийн хохирогчдод үйлчилгээ үзүүлэх "Нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байр"-ыг стандартад нийцүүлж засварлах ажлын зураг төсөл боловсруулах | 1,200,000 | Холбогдох хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт заасан шаардлагыг хангасан байна |
| 15 | Боомын давааны зам засвар, арчлалт /Бүрэнтогтох сум/ зураг төсөл боловсруулах | 2,500,000 | Холбогдох хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт заасан шаардлагыг хангасан байна |
| 16 | Хийморийн овооны тохижилтын /Мөрөн хот, түүний ойр орчмыг харах, зураг авах өндөрлөг хэлбэрээр тохижуулах, замыг нь засварлах шат хийх/ ажлын зураг төсөл боловсруулах | 1,950,000 | Холбогдох хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт заасан шаардлагыг хангасан байна |
| 17 | Тариалан сумын ЗДТГ-ын өргөтгөлийн барилгын ажлын зураг төсөл | 15,000,000 | Холбогдох хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт заасан шаардлагыг хангасан байна |

| | | | |
|----------|--|-------------|---|
| 18 | Эрдэнэбулган сумын 100 ортой дотуур байрны барилгын ажлын зураг төсөв | 29,210,800 | Холбогдох хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт заасан шаардлагыг хангасан байна |
| 19 | Тосонцэнгэл сумын Засаг даргын Тамгын газрын барилгын ажлын зөвлөх | 18,850,000 | Холбогдох хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт заасан шаардлагыг хангасан байна |
| 20 | Мөрөн сумын 5 дугаар цэцэрлэгийн 150 хүүхдийн өргөтгөлийн барилгын ажил | 26,950,000 | Холбогдох хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт заасан шаардлагыг хангасан байна |
| 21 | Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын барилгын инженер геологийн судалгаа | 3,000,000 | Холбогдох хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт заасан шаардлагыг хангасан байна |
| 22 | Галт сумын Засаг даргын Тамгын газрын барилгын инженер геологийн судалгаа | 3,000,000 | Холбогдох хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт заасан шаардлагыг хангасан байна |
| 23 | Галт сумын дотуур байрын барилгын инженер геологийн судалгаа | 3,000,000 | Холбогдох хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт заасан шаардлагыг хангасан байна |
| 24 | Гүүрийн засвар /Ханх сум Жаргалант гол/ зөвлөх | 4,500,000 | Холбогдох хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт заасан шаардлагыг хангасан байна |
| 25 | "Оновчтой бодлого - Хариуцлагатай төсөв" дэд хөтөлбөрийн хүрээнд (Эрүүл мал-Эрүүл хүнс) Гүний худаг гаргах /Тосонцэнгэл сум/ | 200,000 | Холбогдох хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт заасан шаардлагыг хангасан байна |
| 26 | "Оновчтой бодлого - Хариуцлагатай төсөв" дэд хөтөлбөрийн хүрээнд (Эрүүл мал-Эрүүл хүнс) Гүний худаг гаргах /Алаг-Эрдэнэ сум/ | 200,000 | Холбогдох хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт заасан шаардлагыг хангасан байна |
| НИЙТ ДҮН | | 402,820,800 | |